



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/136

Мандагтовь

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн
нөлөөллийн үйл ажиллагааны зардал гаргах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, 16 дугаар зүйлийн 16.4.2, 20 дугаар зүйлийн 20.6, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/130 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр нөлөөлөл, сурталчилгаа урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, үйл ажиллагааны удирдамжийг 2 дугаар, шаардагдах зардлыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Удирдамжийн дагуу үйл ажиллагааг чанартай зохион байгуулж, хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Цэцэг), гишүүдэд үүрэг болгосугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 2 025 200 (Хоёр сая хорин таван мянга хоёр зуу) төгрөгийн зардлыг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Цэцэг)-т даалгасугай.

ДАРГА  Ц.ГАНЗОРИГ



481190069